

## МОНГОЛБАНКНЫ МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ХУРААНГУЙ ТЭМДЭГЛЭЛ

---

№ 24/2

Улаанбаатар хот

Мөнгөний бодлогын хороо (МБХ) 2024 оны 5 дугаар сарын 13-ны өдөр ээлжит бусаар хуралдаж, хуралдааныг Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн удирдав. Хуралдааны эхний хэсэгт мөнгөний бодлогын хэрэгжилтийн талаар Санхүүгийн зах зээлийн газар (СЗЗГ), дараагийн хэсэгт эдийн засгийн өнөөгийн байдал, цаашдын төлөвийг мөнгөний бодлогын саналын хамт Мөнгөний бодлогын газар (МБГ)-аас тус тус танилцуулж, хэлэлцүүлэг өрнүүлэв.

Хуралдааны эхний хэсэгт СЗЗГ-аас мөнгөний бодлогын хэрэгжилтийн талаар танилцууллаа. Нүүрсний экспорт сайн байгаатай холбоотойгоор гадаад валютын орох урсгал энэ оны эхний 4 сард өмнөх оны мөн үеэс 1 тэрбум ам.доллараар сайжирч, цэвэр дүнгээр гадаад валютын урсгал 579 сая ам.долларт хүрлээ. Улмаар гадаад валютын улсын нөөц энэ оны 3 дугаар сард 4.9 тэрбум ам.долларт хүрч, импортын 6.7 сарын хэрэгцээг хангах түвшинд байгааг танилцуулав. Гадаад валютын орох урсгал сайжирсантай холбоотойгоор Төв банкны үнэт цаас (ТБҮЦ)-ны үлдэгдэл энэ оны 4 дүгээр сард 9.7 их наяд төгрөгт хүрч нэмэгдсэн байна. Мөн Төв банкны үйл ажиллагаатай холбоотой томоохон үйл явдлуудыг танилцуулав. Үүнд: Үндэсний баялгийн сангийн тухай хууль батлагдаж, тус сангийн Монголбанк дахь хуримтлалын данснаас орон сууцны ипотекийн санхүүжилтэнд 500 тэрбум төгрөг олгохоор болсноос гадна хадгаламж, зээлийн хүүний зөрүү буурсан, ТБҮЦ-ны хэмжээ нэмэгдсэн, Төв банк дээрх зарим харилцах дансны үлдэгдэлд хүү төлөхөө зогсоосонтой холбоотойгоор ЗБН-ийн хангалтад олгодог байсан хүүгийн урамшууллыг зогсоох шийдвэр гаргасныг тус тус танилцууллаа.

Хуралдааны дараагийн хэсэгт МБГ-аас эдийн засгийн өнөөгийн байдал, цаашдын төлөвийн талаар танилцуулав. Инфляц энэ оны 4 дүгээр сард улсын хэмжээнд 6.4 хувьтай гарч, сүүлийн 5 сарын турш төв банкны зорилтот түвшинд хадгалагдлаа. Импортын бараа бүтээгдэхүүний инфляц саарах хандлага үргэлжилсний зэрэгцээ дотоодын хүнсний гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт тогтворжсоноор инфляц ийнхүү буурлаа. Инфляцад үзүүлэх эрэлт, нийлүүлэлтийн хүчин зүйлсийн нөлөө хүлээлтээс бага байгаагаас шалтгаалан инфляцын богино хугацааны төсөөллийг бууруулсан ба инфляц энэ онд зорилтын орчимд хэлбэлзэхээр байна. Гэхдээ цалин тэтгэврийн өсөлт, төсөв түүнтэй адилтгах санхүүжилтүүдийн нөлөө, төгрөгийн ханш сулрах дарамт нэмэгдэх, зудтай жилийн хаврын саруудад махны үнэ огцом өсөх зэрэг эрсдэлүүд инфляцыг нэмэгдүүлж болзошгүйг дурдлаа.

Үндэсний Статистикийн Хороо (ҮСХ)-ны сарын туршилтын тооцооллоор эдийн засгийн өсөлт эхний улиралд 7.4 хувьтай гарлаа. Гадаад эрэлт тогтвортой байж, уул уурхайн

бүтээгдэхүүний олборлолт өндөр байсан, үйлчилгээний салбарын идэвхжил нэмэгдсэн зэрэг нь эдийн засгийн өсөлтийг тэтгэв. Нүүрсний олборлолт эхний улиралд 21.9 тоннд хүрч, өмнөх оны мөн үеэс 25 орчим хувиар өссөн нь уул уурхайн салбарын үйлдвэрлэл нэмэгдэхэд нөлөөллөө. Харин өвөлжилт хүндэрч, эхний улиралд 6.3 сая толгой мал хорогдож, хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэл 35 хувиар агшив. Ийнхүү зудын нөхцөл байдал төсөөлснөөс хүндэрсэн тул эдийн засгийн өсөлтийн энэ оны төсөөллийг өмнөхөөс бууруулсныг танилцуулав.

Төсвийн тэнцэл энэ оны 1 дүгээр улиралд 1.6 их наяд төгрөгийн ашигтай гарлаа. Төсвийн тэнцвэржүүлсэн орлого 7.3 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 2.5 их наяд төгрөгөөр буюу 53 хувиар нэмэгджээ. Үүнд, уул уурхайн салбарын аж ахуй нэгжүүдийн орлого нэмэгдсэн, ААН-үүдийн өмнөх оны татварын дутуу бүрдүүлэлтүүд эхний улиралд төлөгдсөн зэрэг нь голлон нөлөөлөв. Энэ онд орлогын албан татварын (ОАТ)-ын бүрдүүлэлт өндөр байсан, экспорт, импортын төсөөлөл нэмэгдсэнтэй уялдуулан төсвийн алдагдал өмнөх төсөөллөөс буурах бол ирэх онд төсвийн тэнцлийн төсөөлөл өмнөхийн орчимд байгааг танилцууллаа.

Мөнгөний нийлүүлэлтийн өсөлт 2024 оны 3 дугаар сард 20.9 хувьд хүрч, өмнөх улирлаас бага зэрэг саарлаа. Үүнд, банкны системийн гадаад цэвэр актив (ГЦА)-ын өсөлт саарч, нэгдсэн төсвийн тэнцэл ашигтай байгаа нь нөлөөлөв. Эх үүсвэр талаас М2 мөнгөний өсөлтийг төгрөгийн харилцах, хадгаламж голлон бүрдүүлж байна. Зээлийн өсөлт энэ оны 3 дугаар сард 22.3 хувьд хүрч тогтворжлоо. Сүүлийн саруудад эрчтэй өсөж байсан хэрэглээ, хадгаламж барьцаалсан зээлийн өсөлт саарсан бол бизнесийн зээл 2024 оны 1 дүгээр улиралд өмнөх оны мөн үеэс 2.3 их наяд төгрөгөөр нэмэгдэж, жилийн өсөлт нь 17.1 хувьд хүрчээ. Гэхдээ энэхүү өсөлтийн 40 хувийг хөдөө аж ахуйн салбарыг дэмжих, хүнсний хувьсгалын зээл, 22 хувийг банкуудын хувийн байгууллагад олгосон ногоон зээлүүд тус тус бүрдүүлж байна.

Цаашлаад гадаад эдийн засгийн орчин, төлбөрийн тэнцлийн төлөвийг танилцууллаа. Гадаад эдийн засгийн төлөв өмнөхөөс сайжирч, дэлхийн улс орнуудад инфляц буурах хандлага үргэлжилж байгааг дурдав. Нийт экспорт эхний улиралд 1 хувиар саарч, импорт 27 хувиар тус тус өссөн байна. Нүүрсний экспортой холбоотойгоор дизель түлш болон хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний импортын өсөлт өндөр байгаагийн дээр суудлын автомашины импорт эрчимтэй нэмэгдсэн хэвээр байна. Үргэлжлүүлээд, төлбөрийн тэнцлийн төсөөллийг танилцуулав. Төлбөрийн тэнцэл энэ онд өмнөхөөс бага зэрэг сайжрахаар авч үзсэн бөгөөд үүнд, алт, зэс зэрэг уул уурхайн экспортын бүтээгдэхүүнүүдийн үнийн төсөөлөл нэмэгдэж, экспортын төсөөлөл сайжирсан, Голомт банк гадаад зах зээлээс 300 сая ам.долларын бонд арилжаалсан зэрэг нь голлон нөлөөлөв. Гэхдээ хэрэглээ, хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний импорт төсөөлснөөс өндөр гарсан, орон сууцны ипотекийн санхүүжилт нэмэгдсэн зэрэгтэй холбоотойгоор импортын төсөөллийг өмнөхөөс нэмэгдүүлсэн байна. Эцэст нь гадаад орчны нөхцөл байдал таатай байгаа ч гадаад эрэлт, экспортын үнэ, хэмжээ зэрэгтэй холбоотой суурь эрсдэлүүд хадгалагдсаар байгааг анхаарах нь зүйтэйг дурдлаа.

Ингээд эдийн засгийн гадаад, дотоод орчны нөхцөл байдал, цаашдын төлөвийг харгалзан бодлогын хүүг 1 нэгж хувиар бууруулж, 11 хувьд хүргэх саналыг МБГ-аас танилцууллаа. Тус саналтай холбоотойгоор МБХ-ны гишүүд асуулт асууж, хэлэлцүүлэг өрнүүллээ.


Нэг гишүүний хувьд инфляцын төсөөлөл буурч, зорилтын интервалд хэлбэлзэхээр байгаа тул бодлогын хүүг бууруулах хангалттай орон зай байна. Иймд бодлогын хүүг нэгээс дээш нэгж хувиар бууруулах нь зүйтэй гэсэн саналыг дэвшүүлэв. Харин өөр нэг гишүүний хувьд Холбооны Нөөцийн Сан (ХНС) бодлогын хүүгээ энэ оны эхний хагаст бууруулах хүлээлттэй байсан ч цаг хугацааны хувьд хойшилсоор байгаа нь гадаад эдийн засагт тодорхой бус байдал өндөр байгааг илтгэж байна. Иймээс бодлогын хүүг нэг дор огцом бууруулах нь ханш сулрах, инфляц нэмэгдэх эрсдэлийг үүсгэж болзошгүйг анхааруулав. Түүнчлэн, цалин, тэтгэврийн өсөлт, төсөв, түүнтэй адилтгах санхүүжилтийг дагасан эрэлтийн нөлөө, төлбөрийн тэнцлийн дарамт нэмэгдэх зэрэг эрсдэлүүдийг анхаарч дараагийн шийдвэр гаргах шаардлагатайг дурдлаа.

Харин дийлэнх гишүүдийн зүгээс гадаад эрэлт таатай, экспорт өндөр байгаа нь валютын цэвэр орох урсгалыг дэмжиж байгаагийн дээр хэрэглээний сагсан дахь ихэнх бараа, бүтээгдэхүүний үнэ буурах хандлагатай болж, инфляц энэ онд зорилтот түвшинд хадгалагдахаар байгаа тул эдийн засгийн тогтвортой өсөлтийг дэмжих зорилгоор бодлогын хүүг 1 нэгж хувиар бууруулах нь зүйтэй гэсэн байр суурийг илэрхийлэв. Үүнээс гадна, бодлогын хүүгийн бизнесийн зээлд үзүүлж буй нөлөө, ипотекийн зээл олголтын хүртээмжтэй байдлын талаар судалгааг өргөжүүлэх нь цаашдын шийдвэр гаргалтад чухал нөлөөтэйг онцоллоо. Ийнхүү МБХ-ны гишүүд бодлогын хүүг бууруулах хувь хэмжээний талаар харилцан саналаа хэлэлцэж, бодлогын хүүг 1 нэгж хувиар бууруулж, 11 хувьд хүргэх саналыг 100 хувийн саналаар дэмжлээ.

### **ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:**

Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны 2024 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн ээлжит бус хурлаар эдийн засаг, банк, санхүүгийн зах зээлийн өнөөгийн байдал, гадаад, дотоод орчны төлөв, эрсдэлийг харгалзан үзээд:

1. Бодлогын хүүг 1 нэгж хувиар бууруулж, 11 хувьд хүргэх шийдвэр гаргалаа.



Бодлогын хүүг 1 нэгж хувиар бууруулах